



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 6/123

Хэрлэн сум

**Ж.Саруултөгсийг үргэлжлүүлэн
ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалт, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 489 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Арваннаймдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга Жаахүүгийн Саруултөгс нь хүүхэд асрах чөлөөнөөс хугацаанаас өмнө үүрэгт ажилдаа орох хүсэлт гаргасан тул 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2.Ж.Саруултөгсийн үндсэн цалинг ТЗ-4 зэрэглэлээр тогтоон, 1757000 (нэг сая долоон зуун тавин долоон мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тус тус тооцож, холбогдох бусад нэмэгдлийг олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн Нарийн бичгийн даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ж.Саруултөгсөд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА